

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Улаанбаатар хот

“Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 сарын 29-ний өдрийн 11:00 цагт Өвөрхангай аймгийн нутгийн удирдлагын ордны 203 тоотод эхлэв.

Хурлын ирц:

Хурлын дэгийн дагуу 11:30 хүртэл ирц бүртгэсэн.

Тооллогын комиссын дарга Д.Бадамцэцэг -н танилцуулснаар:

Компанийн 236,277 ширхэг хувьцааг эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 252,608 ширхэг энгийн хувьцааны 93.54% болж байна. Иймд “Компанийн тухай” хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дах заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хурлын дарга Ч.Гүнсэнхорол хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

- 1) Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүү, хөрөнгө тайлан дүгнэлтийг хэлэлцэх,
- 2) 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын байгууллагын тайлан дүгнэлт,
- 3) Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах,
- 4) ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах,
- 5) Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам батлах,
- 6) Компанийн 2017-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, тайлан сонсох,

Мөн хурлын зохион байгуулалт, хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн хуралд оролцож буй оролцогчдыг танилцуулав.

Хэлэлцсэн нь:

- 1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүү, хөрөнгө оруулалтын тайлан дүгнэлтийг хэлэлцэх**

“Баянтээг” ХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг : Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав. Тайланг танилцуулж, асууж тодруулах зүйл байвал нээлттэй хандахыг хүсэв.

2. 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын байгууллагын тайлан дүгнэлт

“Баянтээг” ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Ю.Ариунтунгалаг компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийгдсэн Төрийн Аудитын газрын аудитын дүгнэлтийг уншиж танилцуулав. Аудитын “Хязгаарлалттай” дүгнэлт гарсан үндэслэлийг танилцуулав.

Хуралд оролцогчид хэлэлцсэн асуудлын хүрээнд асуулт асууж, санал солилцов. /Ярианы дэлгэрэнгүй протокол, тэмдэглэл хөтлөх /

3. Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах

“Баянтээг” ХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн зүгээс компанийн төлөвлөгөө болон санхүүгийн зардлын төсөөлөлтэй холбоотой асууж тодруулах зүйлсийг тодруулж, үйл ажиллагатай холбоотой асуудлуудыг хэлэлцүүлэв. /Ярианы дэлгэрэнгүй протокол, тэмдэглэл хөтлөх/

“Баянтээг” ХК-ийн маркшейдер Энхтуяа компанийн 2023 оны хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс тус төлөвлөгөөтэй холбоотой санал, тодруулах зүйлсийг хэлэлцүүлэв. /Ярианы дэлгэрэнгүй протокол, тэмдэглэл хөтлөх/

Хурлын дарга Ч.Гүнсэнхорол “Баянтээг” ХК-ийн олоборлож буй нүүрсийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлж ажиллах тухай Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол болон компанийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг нэмэгдүүлэх зорилгоор уурхай орчмын тодорхой нутаг дэвсгэрийг аймгийн тусгай хэрэгцээнд авах асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байгааг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зорилгоор танилцуулав.

4. ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах

Хурлын дарга Ч.Гүнсэнхорол компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дахин сонгохтой холбоотойгоор ТУЗ-д нэр дэвшихээр хүсэлт ирүүлсэн нэр дэвшигчдийг танилцуулж, мэдээлэл хүргэв. Нэр дэвшигчдийн мэдээлэл:

Ердийн гишүүнд нэр дэвшигч:

- Ч.Гүнсэнхорол
- Б.Ичинноров
- М.Нинжбадгар
- О.Батсүрэн
- Ю.Батсайхан
- Д.Миегомбо

Хараат бус гишүүнд нэр дэвшигч

- З.Дашзэвэг
- Ц.Оюун

- Н.Болдбаатар

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тус асуудалтай холбоотой гарах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам батлах

Хурлын дарга Ч.Гүнсэнхорол “Баянтээг” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын төслийг хурлаар хэлэлцүүлэхээр хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл журмын төсөлтэй танилцан, зохих саналуудыг тусгаж, хавсралтаар батлахаар тогтов.

6. Компанийн 2017-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, тайлан сонсох

Хурлын дарга Ч.Гүнсэнхорол аудитын тайлан хийлгэх болсон үндэслэл болон тайланг танилцуулахаар ирсэн аудитын компанийн төлөөллүүдийг танилцуулж, аудитын тайлангийн үр дүнг танилцуулахыг хүсэв.

Хөндлөнгийн аудитын “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн төлөөлөл Д.Эхбаяр компанийн 2017-2022 оны хөндлөнгийн аудитын дүгнэлт, тайлангаа танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс тайлан дээр дурдагдсан мэдээ мэдээлэл болон, бусад асуудалтай холбоотойгоор асууж тодруулах зүйлсээ тодруулж, хэлэлцэж, санал солилцов. / Ярианы дэлгэрэнгүй протокол, тэмдэглэл хөтлөх /

Хөндлөнгийн аудитын компанийн төлөөлөл О.Алтанцэцэг кассын гүйлгээтэй холбоотой асуудлын бүртгэл, бусад нөхцөл байдлуудыг танилцуулав.

Санал хураалт:

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцүүлсний дараа тооллогын комиссын дарга Д.Бадамцэцэг санал хураалт эхэлж буйг мэдэгдэж, хэлэлцэж байгаа нийт 6 асуудлын 5-д нь ердийн аргаар, 1 асуудал буюу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд кумулятив аргаар санал хураахыг дурдав.

Санал хураалт явагдаж дуусав.

Тооллогын комиссын дарга Д.Бадамцэцэг санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүү, хөрөнгө тайлан дүгнэлтийг хэлэлцэх:

Зөвшөөрсөн – 236,277 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

2. 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын байгууллагын тайлан дүгнэлт:

Зөвшөөрсөн – 236,277 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

3. Компанийн 2023 оны үйл ажиллагаа санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах:

Зөвшөөрсөн – 236,277 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам батлах:

Зөвшөөрсөн – 236,277 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

5. Компанийн 2017-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, тайлан сонсох:

Зөвшөөрсөн – 236,277 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам батлах

Саналын хуудсаар “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүн:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ч.Гүнсэнхорол	11.11%	236'277
2	Б.Ичинноров	11.11%	236'277
3	М.Нинжбадгар	11.11%	236'277
4	О.Батсүрэн	11.11%	236'277
5	Ю.Батсайхан	11.11%	236'277
6	Д.Миегомбо	11.11%	236'277

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	З.Дашзэвэг	11.11%	236'277
2	Ц.Оюун	11.11%	236'277
3	Н.Болдбаатар	11.11%	236'277

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурлын шийдвэр:


1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүү, хөрөнгө оруулалтын тайлан дүгнэлтийг хэлэлцэж, батлав
 - 1.1 “Баянтээг” ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангалттай гэж үзсүгэй
 - 1.2 Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа хангалтгүй байгааг засах, сайжруулах чиглэлээр холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Төлөөлөн Удирдах зөвлөлөөр шуурхай шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.
2. 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын байгууллагын тайлан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
 - 2.1 “Баянтээг” ХК-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Өвөрхангай аймгийн Төрийн аудитын газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 152 дугаар дүгнэлтийг хүлээн авч баталсугай.
 - 2.2 Аудитын хязгаарлалттай дүгнэлтэд дурдсан зөрчил, үүссэн үр дагаварыг арилгах талаар холбогдох шийдвэр гаргаж хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.
3. Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай
 - 3.1 “Баянтээг” ХК-ийн 2023 оны оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт 1-ээр болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хавсралт 2-оор баталсугай.
 - 3.2 Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д үүрэг болгосугай.
 - 3.3 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 18/04 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор нүүрс экспортын гэрээг байгуулж хэрэгжүүлэх, үүнээс шалтгаалан компанийн үйл ажиллагааг өргөтгөхтэй холбоотой хийх өөрчлөлтүүдийг дээрх төлөвлөгөөнд оруулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр тухай бүр нь шийдвэрлүүлж хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-т үүрэг болгосугай.
 - 3.4 Төлөвлөгөөнд тусгагдсан “Баянтээг” ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор тус уурхай орчмын газрыг аймгийн тусгай хэрэгцээнд авах асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн

Хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах
 - 4.1 “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.
 - 4.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болон нарийн бичгийн цалин хөлсийг тогтоосон хэмжээгээр тооцож олгохыг Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг, Ерөнхий нягтлан бодогч Ю.Ариунтунгалаг нарт үүрэг болгосугай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам батлах тухай
 - 5.1 “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг хавсралт 3-аар баталсугай.
 - 5.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Даргад үүрэг болгосугай.
6. Компанийн 2017-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, тайлан сонсох, хэлэлцэх тухай
 - 6.1 Баянтээг” ХК-ийн 2017-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудитын дүгнэлт, тайланг зөвшөөрсүгэй.
 - 6.2 Аудитын дүгнэлтэд дурдсан зөрчлийг арилгах, зохих шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлэхийг Төлөөлөн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг) нарт тус тус даалгасугай.

Хурлын дарга хурлыг хааж үг хэлснээр хурал 19:54 минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:



/Ю.Ариунтунгалаг/

Тэмдэглэл хянасан:



/Ч.Гүнсэнхорол, Хурал даргалагч/

